

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ХУГАЦАА БА ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, АНХААРАХ АСУУДАЛ

Сундуйн Оюунчимэг

ХСИС-н Ерөнхий эрдэмийн сургуулийн , иргэний эрх
зүйн тэнхимийн ахлах багш, магистр, ахлах дэслэгч

Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтын нэг нь иргэнийхэргийг түргэн шуурхай, үнэн зөв шийдвэрлэх явдал бөгөөд үүнд нөлөөлөх хүчин зүйлийн нэгд нь цаг хугацааны асуудал хамаарагдана.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тусгайлан тогтоосон хугацаанд явагддаг бөгөөд тэрхүү хугацааг шүүх бусад оролцогчид заавал дагаж мөрдөнө.

Хугацааг баримтлах нь иргэний хэргийг шуурхай барагдуулах иргэд, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг хамгаалан хангах, оролцогчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа гэдэгт, Иргэний хэргийг хянан шийдвэрлэх, хэрэг шийдвэрлэхтэй холбоотой бусад ажиллагааг гүйцэтгэхэд чиглэгдсэн хуульд заасан эсвэл шүүхээс тогтоосон орон зайны агшинг хамааруулан авч үздэгийг бид дээрх бүлгүүдээр авч үзсэн билээ.

Иргэний хэрэг шийдвэрлэх ажиллагааны хугацааны тухай ойлголт, хугацааг сунгах гэх мэт онол практикийн асуудалд манай улсын эрдэмтэн судлаачид тэр бүр анхаарал тавихгүй байгаа бөгөөдүүний нэг баримт нь түүхэн тодорхой цаг үеүдэд зөвхөн ном, сурах бичгийн хэмжээнд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааны тухай асуудлыг товчхон авч үзсэнийг бид өмнөх бүлгүүдээрээ тодорхой авч үзсэн.

Тэгвэл судалгаанаас үзэхэд эрх зүйн процессын бусад салбарууд болон материаллаг эрх зүйн хүрээнд хугацааг нэг бүрчлэн авч үзэж судласан эрдэмтэн судлаачид байдаг. Тухайлбал: Монгол Улсын Иргэний эрх зүй¹, Монгол улсын Үндсэн хуулийн эрхзүй², Захиргааны эрхзүй³, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй⁴, Захиргааны процесс⁵, гэх мэт бусад салбар эрх зүйн зохицуулалтад хугацааны асуудлыг нэг бүрчлэн тусган авч үзсэн байдаг. Энэ нь зөвхөн эрдэмтэн, судлаачдын үзэл баримтлалаар баталгааждаг зогсохгүй хууль тогтоомж, хууль зүйн практикт нэг мөртөмбөөлөгдсөн ойлголт болжээ.

Үүнээс үзэхэд процессын чиглэлийн түүн дотроо иргэний процессын эрх зүйн хувьд хугацааны тухай асуудлыг авч үзэхгүйгээр эрх зүйн маргаантай асуудлыг бодитой, үнэн зөв, түргэн шуурхай шийдвэрлэх боломжгүй нь тодорхой юм.

Иймд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг авч үзэх нь онол, эрх зүйн зохицуулалтын хувьд чухал асуудал юм. Ингээд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг цаашид ямар байдлаар онол, практик, эрх зүйн зохицуулалтын асуудлыг нь боловсронгуй болговол энэ чиглэлийн харилцаа маргаангүй, түргэн шуурхай, цаг алдалгүй явагдах зэрэг асуудлыг эрдэмтэн судлаачид тэдгээрийн бүтээл тууривал, хууль тогтоомжийн хэрэгжилт, гадаадын улс орнуудын хууль тогтоомжид тулгуурлан дараахь байдлаар авч үзлээ. Үүнд:

Нэгдүгээрт:Хуулиар тогтоож өгсөн хугацааг боловсронгуй болгох чиглэлээр:Хуулиар тогтоосон хугацаа нь урьдчилан хууль тогтоомжоор зааж өгсөн хугацаануудыг хамаарулдаг бөгөөд энэ нь оролцогчдын хүсэл зоригтой холбоогүйгээр тогтоосон хугацаабайдаг.Тухайлбал:Шүүх хуралдааны тэмдэглэлийг хуралдаан дууссан өдрөөс хойш 3 хоногийн дотор бэлэн болгоно. Шүүхийн шийдвэр

¹ Т.Мөнхжаргал, “Монгол Улсын Иргэний эрх зүй”, УБ 2001 он.,

² Н Лүндээжанцан, Ч. Энхбаатар, “МУ-ын Үндсэн хуулийн эрх зүй”, УБ 2000 он.,

³ Т. Долгорсүрэн, “МУ-ын захиргааны эрх зүй”, УБ 2000 он.,

⁴ Б. Бат-Эрдэнэ, “МУ –ын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй”, УБ2004 он.,

⁵ А.Эрдэнэцогт, “Монгол Улсын захиргааны процесс”, УБ 2009 он.,

гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор шүүх өөрийн санаачилгаар буюу хэргийн оролцогчдын хүсэлтээр нэмэлт шийдвэр гаргаж болно⁶. Шүүх гаргасан шийдвэрээ хэргийн оролцогчдод уг шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор өгнө. Энэ тохиолдолд шүүхүүд 8,9,10 дах хоногт нь шийдвэрийн хувийг хүргүүлэх тохиолдол багагүй байдаг бөгөөд энэ нь давж заалдах боломж хугацаа алдагдахад хүргэдэг.

Иймд уг хугацааг багасгаж 3-5 хоногт багтаан хүргэх гэж өөрчлөх нь зүйтэй гэж үзэж байна. Шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор түүнд давж заалдах гомдол эсэргүүцэл гаргана. Давж заалдах шатны шүүх давж заалдах гомдол, эсэргүүцэлтэй хэргийг 30 хоногт багтаан хянан хэлэлцэнэ. Хяналтын шатаар эсэргүүцэл бичигдсэнээс хойш 21 хоногоос хэтрүүлэхгүйгээр хяналтын хуралдаанаар хэлэлцэнэ.

Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрөх эсэхээ нэхэмжлэлийн хувийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор шүүхэд мэдэгдэж, эс зөвшөөрвөл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа ирүүлэх үүрэгтэйгэх мэт хугацаануудыг тогтоосон байна.

Хоёрдугаарт: Шүүхээс тогтоож өгсөн хугацааг боловсронгуй болгох чиглэлээр: Шүүхээс тогтоосон хугацаанд шүүгч хэрэг шийдвэрлэх ерөнхий хугацааны дотор өөрийн үзэмж, санаачилгаар тогтоож аливаа асуудлыг шийдвэрлэж байгаа хугацааг хамааруулах бөгөөд шүүхээс нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамжид шаардлага хангаж ирүүлсэн хугацааг авч үздэг бөгөөд шүүхээр хэрэг хэлэлцэхийг хойшлуулах, түдгэлзүүлэх хугацааг, өөр шүүхээр даалгавар гүйцэтгүүлэх хугацааг гэх мэт хугацааг тогтоосон байна. Энэ хугацааг зөвхөн шүүхээс тогтоож байгаа нь онцлогтой юм.

Учир нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад баримтлах хугацааг дагаж мөрдөх субъектын байдлаас нь хамаарч дараах байдлаар ангилан үздэг.

1. Зөвхөн шүүхээс баримтлах хугацаа
2. Хэргийн оролцогчдын баримтлах хугацаа
3. Бусад оролцогчдоос баримтлах хугацаа зэрэг болно.

Монгол улсын хууль тогтоомжид тусгагдсан байдлыг судлахад ихэвчлэн шүүхээс баримтлах хугацааны асуудал олонтаа байгаа нь ажиглагддаг ба одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуульд шүүхээс баримтлах хугацааг 122,123,170,182-р зүйлүүдэд заажээ. Харин хэргийн оролцогчид, бусад оролцогчдоос дагаж мөрдөх хугацааг төрөлжсөн байдлаар зохицуулж өгөөгүй байна. Мөн хугацааг ихэвчлэн хоногоор тооцох байдлаар оруулсан бөгөөд цаашид шаардлагатай тохиолдолд гадаадын хууль тогтоомжууд зааж өгсөн нэгэн адил “цагаар”, “нэн даруй” биелүүлэх хугацааг ч хуульчилж шаарлагатай юм.

Иргэний процессын буюу шүүхээр иргэний хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон хугацааны практикийг судлан үзэхэд энэ нь:

1. Шүүхээс иргэний хэрэг шийдвэрлэх хуулиар тогтоосон хугацааг хэтрүүлэх
2. Шүүхээс тогтоосон хугацаа нь хэрэгжих үндэслэл муутай, энэ нь ажлын бус цагаар тогтоогдсон байх
3. Хугацааг төрөлжүүлэн зохицуулж өгөөгүйгээс болж эрх зүйн маргааныг түргэн шуурхай, бодитой шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт бүрдээгүй гэх мэт дутагдлууд ажиглагдсаар байна.

Иргэний процессын хугацааг хэтрүүлэх нь өргөдөл гомдол гаргагчдын буюу иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашиг, сонирхол хохирсон үйл ажиллагаа хамгаалах, хангах ажиллагаа хийгдэх, засагдахгүй цаашид үргэлжлэх, процессын бодитой, тогтворгүй байдлыг бий болгож улмаар шүүхийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх зэрэг хор уршигтай байгаа юм.

Иргэний процессын хугацааны асуудал нь эрх зүйн олон төрлийн маргааныг хянан шийдвэрлэх явдалтай тулгардаг бөгөөд тэдгээр маргааны үндсэн суурь нөхцлүүдийг зохицуулсан хуулийн заалт, зохицуулалттай нягт улдаа холбоотой оршиж байдаг. Жишээ нь: Хөдөлмөрийн, Захиргааны эрх зүйн

⁶Мөн хууль., 123-р зүйл.,

харилцаанаас үүсдэг маргаан болох ажлын хөлс, ажилласан жил тогтоолгох зэрэг асуудлыг 60 хоногт хянан шийдвэрлэх нь ямар ч учиргүй зүйл бөгөөд энэ энэ нь маргаан үүссэн гомдолтой нэн их холбоотой байгааг анхаарах нь зүйтэй юм. Өнөө үед ИХШХШ хуулийн 71-р зүйл хугацааг “Хуулиар тусгай хугацаа тогтоогоогүй бол хэргийг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ” гэсэн нь учир дутагдалтай ба энэ нь хуулийн хийдэл бөгөөд иргэний хэрэг шийдвэрлэх хугацааг тоолох нөхцөлийг шүүгчид өөрсдөө мэдэж зохицуулах агуулга хуульд тусгагдсан байна.

Энэ бол хугацааг хэтрүүлэх нэг эрх зүйн үндэслэл төдийгүй хууль бус нөхцөл байдал буй болгож байна. Өөрөөр хэлбэл “Иргэний хэрэг үүсгэсэн” захирамж гаргаснаас хойш 60 хоногт багтаан хэргийг шийдвэрлэх бололцоог бүрдүүлж буй хэрэг юм. Энэ нь хэргийг цаг алдаж, удаашруулах гол нөхцөл болж байгаа төдийгүй шүүгч уг хугацаанд багтаахын тулд хугацаа алдаж үүсгэсэн захирамжиндаа он, сар, өдөр тохируулж бичээд хэрэгт хавсаргах хууль бус дутагдал газар авахад хүргэж байна.

Хуулинд ИХШХА-ны процесс үйл явц бүрд баримтлах хугацааг нарийвчилсан тодорхой байдлаар тусгах нь хэргийг түргэн шуурхай, цаг алдалгүй шийдвэрлэх үндэслэл болохоос гадна шүүх бусад оролцогчдын хариуцлагыг дээшлүүлэх, тэдэнтэй эргэж хариуцлага тооцох үндсэн нөхцөл болно гэж үзэж байна.

Түүнчлэн шүүхээр хянан шийдвэрлэх хэрэг маргааны төрөл, шинж байдлаас хамаарч иргэний хэргийг шүүхэд шийдвэрлэх хугацааг ялгаа заагтайгаар тодорхойлох шаардлага ч байна. Жишээ нь: Албан тушаалтны хууль бус ажиллагааны талаар гаргасан гомдол, нэр төр сэргээх, онцгой ажиллагааны журмаар хэлэлцэх хэргүүдийг нэхэмжлэлийн өргөдлийг хүлээн авснаас хойш 14-20 хоногт багтаан хянан шийдвэрлэх тусгайлсан хугацаануудыг хуулиар тогтоож болох юм. Тэгвэл шүүгчдийн хариуцлага өндөржиж хэрэг үүсгэсэн захирамж гаргасан өдрөөс хойш 60 хоногт гэж тайвширч цаг алдаж суух шаардлагагүй болох бөгөөд цаашлаад иргэний эрх зөрчигдөхгүй болох юм.

Шүүх, шүүгчдийн ажлыг үнэлж дүгнэх зохион байгуулалтын үйл ажиллагаанд эрх зүйн маргааныг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байдлыг нэгэн үзүүлэлт болгож байх, өргөдөл, хэргийн хугацаа хэтрүүлсэн шүүгчдэд хариуцлага тооцдог механизмын боловсронгуй болгох, иргэний процессын хугацааг тасалдах, түр зогсоох, хугацааг үргэлжлүүлэн тоолох, шинээр тоолох гэх мэт асуудлуудыг тайлбарласан тайлбарыг дээд шүүхээс гаргах зэргээр иргэний хэрэг шийдвэрлэх хугацааг чанд баримтлах журмыг мөрдөх нь шаардлагатай байна. Эдгээр нь иргэний хэргийг шуурхай, бодитой шийдвэрлэх, иргэд хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг хамгаалж хангахад ач холбогдолтой.

Мөн нэг хөндөж авч үзэх асуудал бол ИХШХТХ-ийн 119 дугаар зүйлийн 119.3 дахь хэсэгт зааснаар “Шийдвэр хүчинтэй болсон өдрөөс хойш 7 хоногийн дотор шийдвэрийн агуулгыг энэ хуулийн 118 дугаар зүйлд заасны дагуу бүрэн эхээр нь бичгээр үйлдэж, шүүгч, шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурна” хэмээн заагаад мөн зүйлийн 119.4 дэх хэсэгт “шүүх хуралдаанд оролцсон зохигч энэ хуулийн 119.3-т заасан хугацаа өнгөрснөөс хойш 14 хоногийн дотор шүүхэд хүрэлцэн ирж шийдвэрийг өөрөө гардан авна” хэмээн тус тус заасан⁷.

Гэтэл шүүхийн ажлын ачааллаас үүссэн гэх асуудлаас шалтгаалан шүүхээс 7-оос илүү хоногийн хугацаа өнгөрөөд байхад шийдвэрийг бичгийн хэлбэрт оруулж бэлэн болгохгүй байх, шийдвэрийн бичгийн хэлбэрт оруулж зохигчдод мэдэгдээд байхад 14 хүртэл хоногийн хугацаа өнгөртөл ирж авахгүй байх, эсхүл уг хугацааны сүүлийн өдөр ирж авахгүй байх зэргээр процессын үйл ажиллагааны шуурхай байдалд сөргөөр нөлөөлөх байдлууд бий болж байгаа зэрэг асуудлууд бодит байдалдүүсч байна. Дээрх зохицуулалтуудыг цаашид хуулиар нарийвчлан зохицуулж өгөх шаардлагатай ба шүүхээс талуудад энэ тухай мэдэгдсэнээс хойш 14 хоногийн хугацаа өнгөрсөн тохиолдолд хүрэлцэн ирж аваагүй тохиолдолд процессын албадагын арга хэмжээ буюу торгуулийн арга хэмжээг хэрэглэдэг байх эсхүл хүрэлцэн ирж

⁷ Монгол Улсын ИХШХШ тухай хууль, //Төрийн мэдээлэл, № 08., УБ 2002 он

шийдвэрийг гардан авсанд тооцож тухайн өдрөөс эхлэн давж заалдах хугацааг тооцож байх зэргээр зохицуулах шаардлага гарч ирж байна.

Гуравдугаарт: Хууль болон шүүхээс тогтоож өгсөн хугацааг цаашид боловсронгуй болгох асуудал:

1. Иргэний хэргийг шүүх анхан шатны журмаар хянан хэлэлцэх хугацааг хуульд тодорхой заасан байна.Энэ хугацааг шүүх өөрчлөх баримтлахгүй байх эрхгүй. Өөөрөөр ХХША хуульд заасан хугацаанд явагдах учиртай. Тийм ч учраас 71.1-д заасан хугацаа дууссан бол... хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамж гаргана гэж заажээ.Зарим тохиолдолд шүүх хуулийн 71-р зүйлд заасан хугацааг дууссан байхад шүүх хуралдааныг хойшлуулах замаар ХХШ-хугацаагсунгасан гэж үздэг нь алдаатай.Шүүх хуралдаан нь ХХША-ны үндсэн хэсгийн нэг болхын хувьд хуульд заасан ХХШ-хугацааны дотор явагдах ёстой.ИХХШ-хугацааг өөр хуульд өөрөөр заасан тохиолдол энэ хуульд заасан хугацааг баримтлахгүй байх боломж үүснэ гэж зааж өгсөн ба одоогоор иргэний хэргийг өөр хугацаанд шийдвэрлэх хуулийн зохицуулалт байхгүй хэдий ч цаашид байх боломжтой. Тухайлбал:Хэргийн онцлогоос шалтгаалан хүний эрхийг баталгаатай хангах зорилгоор богинсгосон эсхүл уртасгасан хугацааг тогтоох шаардлагатай бол энэ талаарх зохицуулалтыг зөвхөн хуулиар тодорхойлох үндэстэйбайна. Энэ хэсэгт заасан хугацаа ХХШ –дээд хугацаа юм.Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримт хангалттай бүрдсэн гэж үзвэл шүүгч иргэний хэрэг үүсгэснээс хойш 60 хоногийн дотор хэзээ ч шүүх хуралдааныг товлон эрхтэй.Гагцхүү шүүгчийн энэ ажиллагаа хэргийн оролцогчийн эрхийг зөрчөөгүй байх учиртай.

2. Хуульд заасан ХХШ хугацааг тухайн шатны шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөн 30 хүртэл хоногоор сунгаж болно. Шүүгчдийн зөвлөгөөн хэрэг ямар учир шалтгаанаар хугацаандаа шийдвэрлэгдэх боломжгүй болсон, цаашид ямар ажиллагаа хийгдэх шаардлагатай байгааг судлан үзэж, ХХША-г хэдэн хоногоор сунгах тухай бүрт шийдвэрлэнэ. Тухайн хэргийн онцлог, учир шалтгааныг нарийвчлан судлалгүй, ёс төдий хандаж, ХХШХугацааг 30 хоногоор сунгадаг зохисгүй практик тогтсныг шүүхүүд анхаарч цаашид хууль тогтоомжид анхан шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллааг сунгаж давж заалдар болон хяналтын шатны хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг сунгахгүйгээр шийдвэрлэдэг зохицуулалтыг оруулж өгөх нь чухал гэж үзэж байна.

3. ХХША-г тус бүрийн ямар хугацаанд явуулахыг шүүх тогтоож болдог. Харин тухайн ажиллагаанд явуулах хугацааг хуульд шууд заасан бөгөөд хугацаа тогтоох эрх шүүхэд хуулиар олгогдоогүй бол энэхүү ажиллагаа хуульд заасан хугацаанд л явагдах ёстой. Хуулиар тогтоосон хугацааг шүүх өөрөө тогтоох боломжгүй.юм.Харин хуульд зөвхөн дээд хугацааг заасан бол шүүх энэ хугацааны дотор, түүнийг хэтрүүлэхгүйгээр ажиллагаагаа явуулах үүрэгтэй.Хэрвээ хуульд доод хугацааг заасан бол тэр хугацаа өнгөрсний дараа ажиллагаа явуулах учиртай болно.Хэргийн оролцогчдод зориулсан хугацааг хуульд заасан эрхийн дагуу шүүх өөрчлөн тогтоож байгаа бол хуульд заасан хугацааг хязгаарлах үндэсгүй юм. Гэтэл энэ нь бодит байдлын түвшиндээ хэрэгждэггүй шүүхээс тогтоож өгч байгаа хугацаа хууль дээгүүр мэт байгаа нь анхаарал татаж байна.

Шүүхийн практикаас харахад шүүгчид болон шүүхийн байгууллагын ажилтнууд үүнд хамаагүй, зөвхөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талуудаас хамааран энэ хугацаанууд хэтэрдэг, зөрчигддөг гэж үзсэн байна. Иймд цаашид энэ хугацаануудыг нэг бүрчлэн хуульчилж өгөх шаардлагатай байна. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа хаана, аль шатандаа хэний буруугаас болж хэтэрдэг, зөрчигддөг асуудал тодорхой болох магадлалтай юм.

4.Иргэний хэрэг үүсгэснээс хойш хариуцагчид нэхэмжлэлийн нэг хувийг гардуулах хугацааг хуулиар тогтоосон явдал нь хариуцагчид гардуулах ажиллагааг хийхэд зориулагдсан байна. Харин шүүгч нэгэнт иргэний хэрэг үүсгэх захирамж гаргасан бол хариуцагчид энэ талаар мэдэгдэх, нэхэмжлэлийн хувийг түүнд гардуулах ажиллагааг явуулах эсэх талаар эргэлзэх үндэсгүй тул иргэний хэрэг үүсгэсэн

захирамж гарсан өдөр хариуцагчид нэхэмжлэлийн хувийг гардуулахтай холбоотой ажиллагаа эхлэх ёстой юм.

Иргэний хэрэг үүсгэхээс өмнө нэхэмжлэлийг хүлээн авахаас татагалзах үндэслэл байгаа эсэхийг шалгах 7 хоног шүүгчид хуулиар олгогдсон байдаг. Энэ хугацаанд хариуцагч нэхэмжлэлд дурьдсан хаягт оршин суудаг эсэхийг тодруулах боломжтойгоос гадна хаяг тодорхой бус бол нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үүрэгтэй байна. Гэтэл шүүх дээрх 7 хоногийн хугацаанд энэ ажиллагааг хийлгүй иргэний хэрэг үүсгэж хариуцагчид нэхэмжлэлийн хувийг гардуулах үед тэрээр энэ хаягт оршин суудаггүйг мэдэх тохиолдол цөөнгүй гардаг.

Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг гардуулж чадахгүйгээр ХХША-ны хуульд заасан хугацаа хэтрүүлэх тохиолдолд шүүхийн практикт багагүй байдаг. Үүний учир шалтгааныг юуны өмнө шүүх ,шүүгчийн ажлын зохион байгуулалт сул, хуульд заасан арга хэмжээг бүрэн дүүрэн хэрэгжүүлж байгаатай холбоотой гэж үзнэ. Харин хариуцагч нэхэмжлэлийг санаатай хүлээн авахаас зайлсхийж байгаа тохиолдолд хуулийн 77.9 д заасан зохицуулалтыг хуулийн 10.4т заасны дагуу хэрэглэх боломжтой гадна 77.1 ,77.8д заасан зохицуулалтыг ч мөн адил хэрэглэх боломжтой болно. Хариуцагч өөрт нь холбогдуулан ямар асуудлаар иргэний хэрэг үүсгэсэн талаар баттай мэдсэн болохыг баталсан баримт хангатай бүрдсэн бол шүүх энэ тухайн хуулийн 72 ,72.3т заасан зохицуулалтыг хэрэглэх боломжтой.

4.Нэхэмжлэлийн хувийг хүлээн авсан хариуцагч нэхэмжлэлийн шаардлагын талаарх тайлбарыг шүүхэд гаргах үүрэгтэй.түүний тайлбар нь нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь буюу хэсэгчлэн зөвшөөрсөн эсхүл бүхэлд нь буюу хэсэгчлэн татгалзсан хариуцагчийн тайлбарыг авахдаа шүүх талуудын тэгш эрхийн зарчмыг хангасан байх учиртай. Шүүхэд хүрэлцэн ирсэн хариуцагчаас шүүгч асуулт тавьж хариулт авах журмаар тайлбар авдаг практик байдгийг алдаатай гэж үзэж байна.Учир нь нэхэмжлэгч шүүхэд бичгээр шаардлага гаргадагийн адилаар хариуцагч тайлбараа мөнл бичгээр гаргаж элдэв шахалт дарамтгүйгээр хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй юм. Хариуцагчид хариу тайлбар гаргах хугацааг хуульд 14 хоног гэж тодорхойлсон нь мөн л түүнд энэ боломжийг олгож байгаатай холбоотой.шүүх энэ хугацаанаас өөр хугацааг тогтоох эрхтэй боловч хуульд заасан хугацаанаас бага буюу хариуцагчийн эрхийг хязгаарласан хугацааг тогтоож болохгүй. Харин хариуцагч нэхэмжлэлийг гардуулах хугацаа хариуцагчийн санаатай буруутай ажиллагаанаас шалтгаалан хэтэрсэн улмаар ХХША-ны нийт хугацаа давчуу болсон бол хариуцагчаас хариу тайлбар гаргах хугацааг богинсгож тогтоох боломжтой.

5.Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүоооо авсан боловч хуульд эсхүл шүүхээс тогтоосн хугацаанд хариу тайлбараа ирүүлээгүй бол шүүх түүнийг нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөнтэй адил гэж үзэж, хэргийг шүүх хуралдаанаар шийдвэрлэнэ. харин энэ тохиолдолд хуулийн 76.1.1-д заасан үндэслэлүүдийн алиныг нь баримтлах нь тодорхой бус юм. өөрөөр хэлбэл шүүгч хариуцагчийн хариу тайлбар илрүүлэх хугацаа дуусмагц шүүх хуралдааныг зарлах уу, эсхүл ХХШ ерөнхий хугацааг дуустал нь хүлээх үү гэдэгт асуулт тавигдаж байгаа юм.

Нэг талаар хариуцагч хуульд заасан үүргээ мөн хуульд заасан хугацаанд гүйцэтгээгүй тул шүүх хуульд эрх хэмжээний дагуу шүүх хуралдаан хийх боломжтой харагдаж байна. Гэтэл энэ тохиолдолд “хэрэгт ач холбогдолтой нотлох баримт хангалттай бүрдсэн” түүнчлэн “шаардлагатай гэж үзэх” нөхцөл үүссэн гэж үзэх үү.

Нөгөө талаар хаиуцагч хариу тайлбараа хүндэтгэн үзэх шалтгаантайгаар хугацаандаа гаргаж чадаагүй болох нь хожим илэрвэл байдлыг залруулах боломжгүй байдал ч үүсэж болзошгүй юм. нэхэмжлэгч шүүхэд нэхэмжлэлээ гаргахдаа ХХХША- 60 хоног явагдана. гэж мэдэж бай учиртай. Тийм ч учраас хэргийг энэ хугацаанд нь шийдвэрлэх нь талуудын хэн альны эрхэд харш биш гэж санагдаж байна хариуцагчийн эзгүйд хэргийг шийдвэрлэх ажиллагааны онцлогийн талаар хуулийн 100-р зүйлийн тайлбараас үзнэ.

Нэхэмжлэлийн хувийг хүлээн авсан хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг талаарх тайлбарыг шшүхэд гаргах үүрэгтэй хуульд заасан аливаа үүргийг биелүүлэхгүй байх нь хариуцлага хүлээх үр дагавартай байдаг хариуцагч шүүхэд нэхэмжлэлийн хариу тайлбар гаргах үүргэ биелүүлээгүй тохиолдолд түүний эзгүйд өөрөөр хэлбэл түүнд ашиггүй шийдвэр гаргах магадлал өндөртэй байдалд хэрэг шийдвэрлэгдэн гэсэн үг юм. Тэрлэн үүргээ биелүүлээгүй хариуцагч шүүх хуралдаанд биеэр оролцох мэтгэлцэх зэрэг хуульд заасан эрхээсээ татгалзсатай адил нахцөлийг өөрөө үүсгэдэг.

Энэ ноцтой үр дагаварыг хариуцагч мэдсэн сайтар ойлгосон байх учиртай шүүх түүнд энэ талаар дэлгэрэнгүй тодорхой тайлбарлаж өгснөөр ирээдүйд хийгдэж болошгүй ажиллагааны хууль зүйн үндэслэлийг тогтоож өгнө.